

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль, Шуудангийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон бусад холбогдох хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд “Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлсэн санал, гомдлыг хүлээн авах, хянах, шийдвэрлэх журам”-ын дагуу үйлчилгээ эрхлэгч, хэрэглэгчдийн өргөдөл, гомдол, саналыг хүлээн авч шийдвэрлэдэг.

ХХЗХорооны өргөдөл, гомдол, саналыг хүлээн авах хэлбэр:

Тус хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид, аж ахуйн нэгж, иргэдийн гомдол, санал, хүсэлтийг :

- Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төв
- Албан бичиг
- Утас /1800-1858 , 304258/
- Цахим хуудас / www.crc.gov.mn/
- И-мэйл хаягаар / www.info@crc.gov.mn/
- Биечлэн гэсэн хэлбэрээр хүлээн авдаг.

Хүлээн авсан өргөдөл, гомдол:

2026 оны 1-р улирлын байдлаар тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэд , аж ахуй нэгжээс ЗГ-ын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжин 38 , албан бичгээр 42, и-мэйл хаягаар , биечлэн, цахим системээр 21, утсаар 99 нийт 200 өргөдөл , гомдол, санал, хүсэлт хүлээн авсан.

Хүснэгтээр харуулбал:

Гомдол, санал ирсэн хэлбэр	Өргөдөл, гомдол хүлээн авсан суваг					
	Албан бичиг	Утас	11-11 төв	И-мэйл, биечлэн	Цахим хуудас	Бүгд
Санал		3	5		1	9
Гомдол	7	95	31	4	7	144
Өргөдөл, хүсэлт	35	1	2		9	47
Нийт	200					

Ирсэн гомдлыг агуулгаар нь ангилан доорх хүснэгтэд үзүүллээ.

Санал, гомдлыг агуулгаар нь ангилж үзвэл	
<i>Цахим орчинтой холбоотой</i>	16
<i>Үйлчилгээний төлбөр, үнэ тариф</i>	30
<i>Үйлчилгээний чанар (интернэтийн хурд, сүлжээний муу)</i>	32
<i>Үйлчилгээ, үйл ажиллагаа</i>	84
<i>Радио долгионы үүсгэх цахилгаан соронзон оронгийн хүний биед үзүүлэх нөлөө, харилцан нөлөөлөл</i>	29
<i>Нөхцөл шардлага, стандарт дүрэм, харилцах холболт, ТЗ олголт</i>	3
<i>Хамааралгүй</i>	6

Тус хороонд хуулиар олгогдсон гомдол хүлээн авах шийдвэрлэх эрх хэмжээний хүрээнд хамаарах агуулгаар ангилж харуулсан болно. Хэрэглэгчээс ирүүлсэн дээрх төрлийн өргөдөл, гомдлуудыг тус хороо нь хүлээн аваад холбогдох үйлчилгээ эрхлэгчид болон тус хорооны хариуцсан газруудын мэргэжилтэнд шилжүүлэн хэрхэн шийдвэрлэсэн талаараа гомдол гаргагчид хариу өгөхийг үүрэг болгох, тайлбар мэдээлэл өгөх зэргээр шийдвэрлэдэг.

Холбогдох үйлчилгээ эрхлэгчээс гомдлыг хэрхэн барагдуулсан талаар хариу ирүүлсний дараа өргөдөл, гомдол гаргасан хэрэглэгчид мэдэгдэн гомдлыг хааж, шийдвэрлэгдсэнд тооцдог.

2026 оны 1-р улирлын байдлаар хүлээн авсан нийт 200 өргөдөл, гомдлоос :

1. Цахим орчинтой холбоотой	16
2. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчтэй холбоотой	22
3. Радио, телевиз үйлчилгээ эрхлэгчтэй холбоотой	15
4. Эрүүл ахуйн дүгнэлт, харицан нөлөөлөлтэй холбоотой	29
5. Үүрэн холбооны эрхлэгчтэй холбоотой	73
6. Хорооны үйл ажиллагаа, эрхлэх асуудлын хүрээнд	20
7. Интернэтийн үйлчилгээ эрхлэгчтэй холбоотой	6
8. Тусгай дугаар үйлчилгээ эрхлэгчтэй холбоотой	3
9. Шуудангийн үйлчилгээ эрхлэгчтэй холбоотой	7
10. Суурин холбооны үйлчилгээ эрхлэгчтэй холбоотой	3
11. Буцаасан / хамааралгүй /	6

Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжин 38 өргөдөл гомдол ирсэн. Үүнээс:

Радио, телевиз	7
Суурин холбооны үйлчилгээ эрхлэгч	1
Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгч	7
Хорооны үйл ажиллагаа, эрхлэх асуудлын хүрээнд	3
Цахим орчинтой холбоотой	6
Шуудангийн үйлчилгээ эрхлэгч	7
Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч	1
Интернэтийн үйлчилгээ эрхлэгч	2
Тусгай дугаар	1
Буцаасан / хамааралгүй/	3

Ирүүлсэн 200 өргөдөл, гомдол , хүсэлтэд хариу тайлбар өгч шийдвэрлэж ажилласан.

Доорх хүснэгтээр тус хороонд ирсэн өргөдөл, гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар үзүүлэв.

Шийдвэрлэлт	
<i>Холбогдох арга хэмжээ авсан</i>	13
<i>Холбогдох үйлчилгээ эрхлэгчид дамжуулан шийдвэрлэсэн</i>	88
<i>Хэмжилт, шалгалт хийсэн</i>	29
<i>Тайлбар мэдээлэл, хариу албан тоот өгч шийдвэрлэсэн</i>	64
<i>Буцаасан</i>	6

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц:

- Нийт - 200
- Шийдвэрлэсэн - 200
- Шийдвэрлэлтийн явц – 100%

- Дундаж хугацаа – 10.5 өдөр